

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 26.1.4 дэх заалт нэмсүгэй:

“26.1.4. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй, 14.1, 16.6-д заасан зөвшөөрөлгүй барьсан барилга, байгууламжийг буулгах тухай шийдвэрийг эрх бүхий хяналт хэрэгжүүлэгч болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн шүүх гаргана.”

**2 дугаар зүйл.** Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “иргэнийг” гэсний өмнө “бол үйл ажиллагааг зогсоож, гэм буруутай” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллах барилгын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний” гэж, 25.2 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай” гэснийг “Хяналтын тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Барилгын тухай хуулийн 25.4, 25.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Автотээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “бол” гэсний дараа “цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Автотээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“20 дугаар зүйл.Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих зохицуулалт, хяналт**

20.1.Автотээврийн зохион байгуулалт, автотээврийн салбарт тавих технологийн хяналтыг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага техникийн үзлэг оношилгоогоор болон олгосон зөвшөөрөл, байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хяналтын тухай хуулийн 7.5-д заасны дагуу зохицуулалтаар хэрэгжүүлнэ.

20.2.Автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай иргэн, хуулийн этгээдэд захиргааны хариуцлага ногдуулах саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.”

20.3.Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлт, тээврийн техникийн ашиглалтын байдалд бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага хяналт тавина.

20.4.Тээврийн болон тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг тээврийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд Хяналтын тухай хуулийн 7.3-т заасан хүрээнд нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.”

**3 дугаар зүйл.**Автотээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “автотээврийн улсын байцаагч” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтаас “11.2.1, 11.2.2, 11.2.3, 11.2.4, 11.2.5, 12.4” гэснийг, 23.1.2 дахь заалтаас “11.2.6, 11.2.8, 11.2.9” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Автотээврийн тухай хуулийн 21, 22 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “болон” гэсний дараа “цагдаагийн,” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “шүүгч” гэсний дараа “цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/“15 дугаар зүйл.** Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих зохицуулалт, хяналт

15.1. Усан замын тээврийн зохион байгуулалт, усан замын тээврийн салбарт тавих технологийн хяналтыг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгосон зөвшөөрөл, байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хяналтын тухай хуулийн 7.5-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

15.2. Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлт, усан замын хэрэгслийн техникийн ашиглалтын байдалд бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага хяналт тавина.

15.3. Усан замын тээврийн болон тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг тээврийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд Хяналтын тухай хуулийн 7.3-т заасан хүрээнд нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.”

**2/16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт:**

“16.1.1.энэ хуулийн 12.2 дахь хэсгийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;”

**3 дугаар зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “улсын мэргэжлийн” гэснийг “нэгдсэн хяналтын” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “усан замын тээврийн хяналтын улсын байцаагч” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Авто замын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “дарга” гэсний дараа “захиалагч, зураг төсөл зохиогч,” гэж, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “бол” гэсний дараа “шүүгч эсхүл” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Авто замын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “Төрийн хяналт, шалгалтын тухай хууль” гэснийг “Хяналтын тухай хууль” гэж, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 18.5 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааныбайгууллагаас” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийн “шийдвэртээ” гэсний дараа “түр зогсоох болон” гэж, 32.7 дахь хэсгийн “ажиллагааг” гэсний дараа “түр зогсоосон” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “9.1.20” гэсэн дугаарыг “9.1.22” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “эрчим хүчний хяналтын улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих шийтгэл ногдуулж,” гэснийг “тусгай зөвшөөрөл олгогч” гэж, 32 дугаар зүйлийн 32.1, 32.3, 32.4 дэх хэсгийн “түтгэлзүүлнэ” гэснийг “түр зогсоох” гэж, 32.5 дахь хэсгийн “ажиллагаа” гэснийг “ажиллагааг түр зогсоох” гэж, “түтгэлзүүлж” гэснийг “түр зогсоож” гэж, 32.6 дахь хэсгийн “түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан тухайгаа түдгэлзүүлсэн” гэснийг “түр зогсоосон тусгай зөвшөөрөл эзэмшигч, түтгэлзүүлсэн хэрэглэгч нь шалтгааныг арилгасан тухайгаа” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “эрчим хүчний улсын хяналтын байгууллага, улсын байцаагч” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний улсын байцаагч” гэж, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн 3 дахь заалтын “30.1-д заасан болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй” гэснийг “30.1.3-д заасан үүргээ биелүүлээгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.7, 30.1.9 дэх заалтыг тус тусхүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30.2.2.хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд захиргааны хариуцлага ногдуулах саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх.”

**2 дугаар зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “Зохицуулах хороо Хяналтын тухай хуулийн 7.5-д заасны дагуу” гэж, 30.2 дахь хэсгийн “Улсын байцаагч Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна” гэснийг “Зохицуулах хороо” гэж, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “харилцаа холбооны улсын байцаагч” гэснийг “шүүгч ” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.** Шуудангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “Зохицуулах хороо Хяналтын тухай хуулийн 7.5-д заасны дагуу” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “шүүгч” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “болон харилцаа холбооны улсын байцаагч” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “харилцаа холбооны улсын байцаагч буюу” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.** Радио долгионы тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “захиргааны” гэснийг “мэргэжлийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.Хэмжил зүйн хяналтыг нэгдсэн хяналтын байгууллагын хэмжил зүйн улсын байцаагч хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хяналт” гэснийг “хяналтад” гэж, 7.4 дэх хэсгийн “хяналт” гэснийг “хяналтыг” гэж, 18 дугаар зүйлийн 18.6.4 дэх заалтын “хяналт” гэснийг “хяналтыг” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын “хяналт” гэснийг “хяналтад” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 3 дугаар бүлгийн гарчгийн “шалгалт”, 7 дугаар зүйлийн гарчгийн “төрийн”, “шалгалт”, 7.2 дахь хэсгийн “төрийн”, “шалгалтад” 7.4 дэх хэсгийн “төрийн”, “шалгалтын”, 18.6.4 дэх заалтын “төрийн”, “шалгалтыг”, 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын “төрийн”, “шалгалтад” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөннайруулсугай:

“28.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих;”

**2 дугаарзүйл.**Боловсролын тухайхуулийн24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын байгууллагын” гэснийг “холбогдох эрх бүхий байгууллагын” гэж өөрчилсүгэй.

**3 дугаарзүйл.**Боловсролын тухайхуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийн “боловсролын улсын байцаагч” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.**Боловсролын тухайхуулийн 37 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Донорын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын алба нар” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“42.1. Эрүүл мэндийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, шинжилгээ хийх, шалгах, дүгнэх, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар шалгалт хийх, шалгалтын дүнг мэдээлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг буруутай албан тушаалтнаар арилгуулах, хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж танилцуулах, хангуулах чиг үүргийг эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналт хариуцсан алба хэрэгжүүлнэ.

42.2. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг Хяналтын тухай хуулийн 7.3-т заасан хүрээнд нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Соёлын өвийг хамгаалах тухайхуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн “соёлын” гэсний дараа “өвийн” гэж, 23.2 дахь хэсгийн “23.1.3” гэсний дараа “23.1.7” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухайхуулийн22<sup>1</sup> дүгээр зүйлийн 22<sup>1</sup>.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх” гэснийг “соёлын өвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага”, 22<sup>1</sup> дүгээр зүйлийн 22<sup>1</sup>.2 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага” гэснийг “Энэ хуулийн 22<sup>1</sup>.1-д заасан байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаарзүйл.**Соёлын өвийг хамгаалах тухайхуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “23.1.7-д заасан зөрчлийг соёлын хяналтын улсын байцаагч” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын тухайхуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “соёлын хяналтын улсын байцаагч” гэснийг “шүүгч” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Соёлын тухайхуулийн 22<sup>1</sup> дүгээр зүйлийн 22<sup>1</sup>.1, 22<sup>1</sup>.2 дахь хэсгийн “соёлын улсын хяналтын алба, улсын байцаагч,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Соёлын тухайхуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг, 22<sup>1</sup> дүгээр зүйлийн 22<sup>1</sup>.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “шүүгч” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, 28.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалтуудыг нэмсүгэй:

**1/28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.4 дэх заалт:**

“3/хуульд тусгайлан заасан тохиолдолд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;

4/хуульд тусгайлан заасан тохиолдолд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл, нөхөн төлбөр ногдуулах, төлбөрийг барагдуулах;”

**2/28 дугаар зүйлийн 28.2.8 дахь заалт:**

“8/уг зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох бүх баримт сэлтийг цагдаагийн байгууллагад шилжүүлэх.”

**2 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “байгуулах” гэсний дараа “захиргааны хяналтыг хэрэгжүүлэх” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.1, 28.1.2 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг:**

“26.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

26.2. Аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчны аюулгүй байдалд нөлөөлж буй байдлын хяналтыг Хяналтыг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн 7.3-т заасан хүрээнд нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

**2/28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.1, 28.1.2 дахь заалт:**

“1/тухайн нутаг дэвсгэртээбайгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

2/хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;”

**4 дүгээр зүйл.**Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 26.4.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### АРИУН ЦЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Ариун цэврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3дахь заалт,18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 14дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

“10.1.10.Эрдэс баялгийн нөөц, уурхайн хаалтын үйл ажиллагаанд энэ хууль болон Хяналтын тухай хуульд заасны дагуу хяналт тавих.”

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 19 дүгээр зүйлийн 19.10, 22 дугаар зүйлийн 22.3, 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн,35 дугаар зүйлийн 35.2.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын албаар” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар” гэж, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын албаны” гэснийг “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.4, 39 дүгээр зүйлийн 39.1.6,39.1.7 дахь заалтын “мэргэжлийн хяналтын албанд”, “байгаль орчны хяналтын албанд” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж, 37 дугаар зүйлийн 37.2, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.1,38.1.5 дахь заалтын “байгаль орчны хяналтын алба” гэснийг “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж, 45 дугаар зүйлийн 45.2,49 дүгээр зүйлийн 49.11 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын алба” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 47 дугаар зүйлийн 47.9,48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын албанд” гэснийг “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 47 дугаар зүйлийн 47.11 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын албанаас” гэснийг “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас” гэж, “албанд” гэснийг “байгууллагад болон нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж,49 дүгээр зүйлийн 49.4.4 дэх заалтын “байгаль орчны хяналтын албаны” гэснийг “аймаг, нийслэлийн байгаль орчны газрын” гэж, 55 дугаар зүйлийн 55.3.2 дахь заалтын “байгаль орчны хяналтын албаны” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“11.2.4. ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах;”

**2 дугаар зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 14.2 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг” гэснийг “Хяналтын тухай хуулийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгийн “байгаль орчны хяналтын улсын байцаагч” гэснийг “шүүгч” гэж, 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “эрх олгогдсон байгаль орчны хяналтын газар” гэснийг “газрын” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалтын “зохих мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан албан тушаалтан буюу” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухайхуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “хамгаалагч” гэсний дараа “тухайн нутаг дэвсгэртээ” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухайхуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “үүрэгтэй байна.” гэснийг “үүргийг хэрэгжүүлнэ.” гэж, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “байгал орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухайхуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын төв” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын төв байгууллагын тодорхойлолт” гэснийг “Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.1. Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ;

15.2. Хяналтын улсын байцаагч нь иргэн, хуулийн этгээдийн ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ Хяналтын тухай хуулийн 20, 21, 22, 23-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;”

**2 дугаар зүйл.** Ургамал хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “мэргэжлийн хяналтын төв байгууллагын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “эрх бүхий” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Ургамал хамгааллын тухай хуулийн Зургаадугаар бүлгийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг, 15 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын алба” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “улсын мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны ” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Агаарын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллага хуулиар хүлээсэн эрх хэмжээнийхээ хүрээнд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалт:**

“4.1.51. “Засгийн газрын санхүүгийн дотоод хяналт” гэж төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар олгогдсон эрхийн үйлчлэх хүрээний хуулийн этгээдийн санхүү, төсөв, худалдан авах ажиллагаа, хөрөнгө өр төлбөрийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн Засгийн газрын дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг.”

**2/ 69<sup>1</sup> дүгээр зүйл:**

“69<sup>1</sup> дүгээр зүйл. Засгийн газрын санхүүгийн дотоодын хяналт

69<sup>1</sup>.1.Засгийн газрын санхүүгийн дотоод хяналтыг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санхүүгийн хяналт, шалгалтын нэгж, санхүүгийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

69<sup>1</sup>.2.Засгийн газрын санхүүгийн дотоод хяналтад төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, тусгай зориулалтын сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Засгийн газрын хувь оролцоо бүхий бусад хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар олгогдсон эрхийн үйлчлэх хүрээний хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа түүнийг хэрэгжүүлэхэд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсвийн болон Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэнд гүйцэтгэлийн хяналт тавих үйл ажиллагаа хамрагдана.

69<sup>1</sup>.3.Засгийн газрын санхүүгийн хяналт, шалгалтын зарчим, чиглэл, тэдгээрийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газрын тогтоолоор батална.

69<sup>1</sup>.4.Санхүүгийн хяналт, шалгалтыг тухайн байгууллагын хүсэлт, дээд шатны байгууллагын шийдвэрээр хийж болно.

69<sup>1</sup>.5.Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч нь шалгуулсан байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүн, төсөвт хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, гэрээний хэрэгжилт, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагаа болон төрийн сангийн ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгнө.

69<sup>1</sup>.6.Санхүүгийн хяналтын улсын байцаагч нь хуульд өөрөөр заагаагүй бол санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ Хяналтын тухай

хуулийн 20, 21, 22, 23-д заасан нийтлэг үүргийг хүлээж, бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд шалгалтаар тогтоогдсон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон нэгдсэн акт, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн баримт бичиг үйлдэнэ.

69<sup>1</sup>.7. Санхүүгийн хяналтын улсын байцаагч үйл ажиллагаанд ашиглагдах хэвлэмэл хуудас, торгуулийн хуудасны загварыг санхүү, төсвийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

69<sup>1</sup>.8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба нь санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа болон дотоод аудитын үйл ажиллагааг нэг байгууллагад давхардуулахгүй, эрсдэлийн үнэлгээнд суурилсан байх зарчим баримтална.

69<sup>1</sup>.9. Санхүүгийн дотоод хяналтын нэгдсэн төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүр батлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутам Засгийн газарт танилцуулна."

**2 дугаар зүйл.** Төсвийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49 дахь заалт:**

"4.1.49. "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулахад эрсдэлийн удирдлагаар хангах, дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлэн удирдлагад баталгаа өгөх, тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж, дүгнэлтээр хангах үйл ажиллагааг;"

**2/Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэг:**

"69.2. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, мэдээллийн нэгдсэн сан бий болгох, нийтээр дагаж мөрдөх улсын салбарын дотоод аудитын болон санхүүгийн хяналтын дүрэм, журам, заавар, аргачлал, маягт баталж, мөрдүүлэх, дотоод аудиторыг бэлтгэх, мэргэшүүлэх, эрх олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна."

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналт шалгалт,” гэснийг “санхүүгийн хяналт шалгалт, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх дотоод аудит” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “Төрийн хянан шалгах хороо,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “69” гэсний дараа “, 69<sup>1</sup>” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай 52<sup>1.3</sup> дахь хэсгийг нэмсүгэй:

“52<sup>1.3</sup>. Төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн үйл ажиллагаанд ашиглагдах хэвлэмэл хуудас, торгуулийн хуудасны загварыг батална.”

**2 дугаар зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52<sup>1.2</sup> дахь хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“52<sup>1.2</sup> Худалдан авах ажиллагааны улсын байцаагч нь худалдан авах ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хөдөлмөрийн”, 33 дугаар зүйлийн 33.2, 33.4 дэх хэсгийн “Хөдөлмөрийн” гэсний дараа “аюулгүй байдлын” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“33.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх” гэснийг “туршилт тохируулга, баталгаажуулалт хийх итгэмжлэгдсэн лаборатори бүхий мэргэжлийн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдээр хянуулж, баталгаажуулсан байх” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн “хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “улсын мэргэжлийн хяналтын байгууллага, алба,” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2, 36.3, 36.4, 36.5 дахь хэсгийн “хөдөлмөрийн хяналтын” гэснийг “эрх бүхий” гэж, 36.5 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж, хөдөлмөрийн эрүүл ахуйн дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөл аваагүй” гэснийг “туршилт тохируулга, баталгаажуулалт хийх итгэмжлэгдсэн лаборатори бүхий мэргэжлийн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдээр хянуулж, баталгаажуулаагүй” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“140.1.Хөдөлмөрийн хяналтыг улсын хэмжээнд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах төрийн бус байгууллага, орон нутагт бүх шатны Засаг дарга хэрэгжүүлэх бөгөөд аж ахуйн нэгж байгууллагад дотоодын хяналтаар зохион байгуулна.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.15, 141.1.18 дахь заалтын “хөдөлмөрийн улсын байцаагч” гэснийг “шүүгч” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1.1 дэх заалтын “хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэснийг, 139.1.2 дахь заалтын “хяналтын алба” гэснийг, 141 дүгээр зүйлийн 141.1.5, 141.1.6, 141.1.11 дэх заалтын “хөдөлмөрийн улсын байцаагч буюу” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 140.2, 140.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.1.2. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн улсын байцаагч буюу” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Энэ хуулийн хэрэгжилтэд ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах төрийн бус байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн улсын байцаагч буюу” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, 24.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.7.Нийгмийн халамжийн хяналтыг нийгмийн халамжийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

24.8.Нийгмийн халамжийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.2. Даатгалын үйл ажиллагаанд нийгмийн хамгааллын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, улсын байцаагч хяналт тавина.”

**2 дугаар зүйл.** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсгийг нэмсүгэй.

“18.2.Энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 12.4, 13.2, 14.2-ыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч албан тушаалтныг 500000-1000000 төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг” гэснийг “нэгдсэн хяналтын болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны саналыг” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “дарга” гэснийг “даргаас” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн хяналтын байгууллагаас” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.** Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “Мэргэжлийн хяналтын алба” гэснийг “Нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын “Мэргэжлийн хяналтын” гэснийг “Нэгдсэн хяналтын” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Орон сууцны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.Орон сууцны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч энэ зүйлийн 18.1.1, 18.1.3, 18.1.4, 18.1.5, 18.1.6-д, улсын байцаагч 18.1.4. 18.1.5-д заасан зөрчлийг хянан шалгаж, дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна.”

**2 дугаар зүйл.** Орон сууцны тухай хуулийн 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1.2</sup> дахь хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Орон сууцны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “холбогдох мэргэжлийн хяналтын алба” гэснийг, 17.2 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын алба” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, “Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар<sup>7</sup>” гэснийг “Хяналтын тухай хуулиар” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 18 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.2.4. ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах;”

**2 дугаар зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 14.2 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг” гэснийг “Хяналтын тухай хуулийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2 дахь хэсэг нэмсүгэй:

“23.2.Энэ зүйлийн 23.1.7-д заасан төрийн албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг шүүгч, 23.1.1-23.1.6-д заасан хариуцлагыг шүүгч эсхүл улсын байцаагч ногдуулна.”

**2 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/17 дугаар зүйлийн 17.4.3 дахь заалт:**

“17.4.3.Урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглахдаа хамгаалалтын бүсийг нийтийн аюулгүй байдлын нэгдсэн хяналтын байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 500 метрээс багагүй зайд;”

### **2/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:**

“23.1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах захиргааны хариуцлага ногдуулна.”

**3 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсгийн “эрүүл мэндийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “эрүүл мэнд, байгаль орчны хяналтын алба, технологийн горимд дэд бүтцийн хяналтын алба” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Цахим гарын үсгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “харилцаа холбооны улсын байцаагч” гэснийг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “эсхүл харилцаа холбооны улсын байцаагч” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Цахим гарын үсгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ДАВС ИОДЖУУЛЖ, ИОД ДУТЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “этгээдэд” гэсний дараа “шүүгч эсхүл” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.2.Иоджуулсан давсны чанарт тавих хяналтыг Хяналтын тухай хуулийн 7.3, 29-т заасан байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дархлаажуулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“21.1.2. Энэ хуулийн 6.2.3-ыг зөрчсөн бол заавал нөхөн дархлаажуулалтад хамруулан, гарсан зардлыг тухайн иргэнээр төлүүлэх;”

**2 дугаар зүйл.** Дархлаажуулалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “холбогдох эрх бүхий мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “эм биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын улсын алба, эмчилгээний чанарын хяналтын байцаагч” гэснийг “эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөл” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Дархлаажуулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## **СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн “барилгын хяналтын” гэснийг “мэргэжлийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалтын “эрх бүхий байгууллага” гэснийг “мэргэжлийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “буюу улсын байцаагч” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “улсын мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“17.1.5.Нөөцийн бараа, материалыг хадгалах барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд чанар, стандарт, эрүүл ахуй болон ургамал хорио цээрийн чиглэлээр холбогдох мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулсан байх.”

**2 дугаар зүйл.** Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “мэргэжлийн хяналтын байгууллагын” гэснийг “мэргэжлийн байгууллага, шинжээчийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллагын” гэснийг “холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээчийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын “мэргэжлийн хяналтын байгууллагын” гэснийг “холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээчийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “хүнс хөдөө, аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгж” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Улсын нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын улсын байцаагч” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5.1.5 дахь заалт нэмсүгэй.

“5.1.5.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажил, ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах, байгалийн гамшгаас сэргийлэх мэдээний хангалт, ашиглалтын талаар дагаж мөрдүүлэхээр гаргасан хууль тогтоомж, журам, зааврын биелэлтэд хяналт тавих.”

**2 дугаар зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “ус цаг уур” гэсний өмнө “энэ хуулийн хэрэгжилтэнд болон” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хангах” гэсний дараа “хяналт тавих.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “буюу улсын байцаагч” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 17 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## **ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн “этгээдэд” гэсний дараа “шүүгч эсхүл” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.9 дэх заалтын “улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзлэг шалгалт явуулах,” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аялал, жуулчлалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “болон мэргэжлийн”, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “аялал жуулчлалын” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.** Аялал, жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.2, 24.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сogтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “харьяалах байгууллагын дотоод хяналтын нэгж” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.8.Импортолж болох согтууруулах ундааны жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг импортлохдоо дээжийг нь нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар шинжлүүлж, баталгаажуулсан байна.”

**2 дугаар зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь хэсэг, 4.6.3 дахь заалт, 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1.1</sup> дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 14.3.4 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хилийн эрүүл ахуйн хяналтын алба” гэснийг “хил дээрх нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1. Геодези, зураг зүйн төрийн хяналт нь геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх заавар, дүрмийн биелэлтийг хангуулна.

8.2. Геодези, зураг зүйн төрийн хяналтыг нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний улсын байцаагч хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “геодези, зураг зүйн” гэснийг “эрх бүхий” гэжтус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.9 дэх заалтад “боловсрол олгох үйл ажиллагаа (боловсрол олгох байгууллагаас сургалтын хөтөлбөр болон стандартын шаардлагыг хангаж буй байдал);” гэж, 20.5.5 дахь заалтад “санхүүгийн хяналт шалгалт” гэж, 20.5.11 дахь заалтад “соёлын өвийн хамгаалалын хяналтын асуудал” гэж, 20.5.15-д “нийгмийн даатгалын хяналтын асуудал” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1 дэх заалтын “тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “нийтийн аюулгүй байдлын” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Өрсөлдөөний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ба мөн хуулийн 11 дүгээр” гэснийг “Хяналтын тухай хуулийн 20, 21, 22, 23 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ба мөн хуулийн 24 дүгээр” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалтын “мэргэжлийн хяналт шалгалтын болон” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Тариалангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэсний дараа “улсын” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Тариалангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.35 дахь заалт, 32 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## **ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “мэргэжлийн хяналтын байцаагчийн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.1.Стандарт, тохирлын үнэлгээний талаарх хяналтыг улсын хэмжээнд нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай” гэснийг “Хяналтын тухай” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь заалтын, 25 дугаар зүйлийн гарчгийн, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсгийн “албан тушаалтныг 50000-60000” гэснийг, 27.1.6 дахь хэсгийн “албан тушаалтныг 30000-50000” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.4, 25.5.2, 25.5.3, 25.5.4, 25.6.1, 25.6.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт:**

“7.1.8.Чөлөөт бүс дэх хяналтын албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;”

**2/9 дүгээр зүйл. Чөлөөт бүс дэх хяналтын алба**

“9.1.Чөлөөт бүсэд хяналтын бие даасан алба ажиллана. Хяналтын албаныорон тооны хязгаар зохион байгуулалтыг чөлөөт бүсийн хэлбэр, байршил, үйл ажиллагааны онцлогоос хамааруулан Засгийн газар тогтооно.”

**3/11 дүгээр зүйлийн 11.4.4 дэх заалт:**

“11.4.4.Хяналтын албаны зардал.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ  
ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ  
ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “байр,” гэсний дараа “дүрэмт хувцас” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1. Улсын байцаагч нь Хяналтын тухай хуулийн 20, 21, 22, 23 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;”

**3 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 5.2 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 5.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 12.2, 12.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1-23.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтын “улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДАА ЗОХИЦУУЛАХ ТУХАЙХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээрзүйл.**Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа зохицуулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “болон” гэсний дараа “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан байгууллага” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа зохицуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналт хариуцсан” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээрзүйл.**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:**

“6.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүрд энэ тухай нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэнэ.”

### **2/8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг:**

“8.4.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай зөвшөөрөл авахыг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах шаардлага, тусгай нөхцөлийг хангасан агуулахтай байна.”

**2 дугаар зүйл.**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бол” гэсний дараа “шүүгч” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“6.1.Хууль хамгаалах байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулна;”

**3 дугаар зүйл.** Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай 6 дугаар зүйлийн гарчигийн “Хууль хяналтын” гэснийг “Хуулийн” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “7.1.1-д заасныг биелүүлээгүй” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “этгээдэд” гэсний дараа “шүүгч буюу” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

### **1/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:**

“8.1.Малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хяналтыг Хяналтын тухай хуулийн 7.3, 29-т заасан нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

### **2/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:**

“10.1.Улсын байцаагч нь малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн талаарх аж ахуйн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ Хяналтын тухай хуулийн 20, 21, 22, 23-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;”

**3 дугаар зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “Малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хяналт” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийг “Малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хяналтын байгууллага, тогтолцоо” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний технологийн” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “дүгнэлт гаргах” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.2.1 дахь заалтын “6.1.1-6.1.4, 6.1.7, 6.3.2, 6.3.3, 6.4.1-6.4.3, 6.4.6, 6.4.7, 7.4, 14.2.5, 14.2.7,” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтын “14.2.6” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 7, 8, 9, 10, 11, 12 дахь заалт, мөн зүйлийн 10.2 дахь хэсэг, мөн хэсгийн 10.2.1, 10.2.2, 10.2.3 дахь заалт, мөн зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## **ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:**

“9.1.Таримал ургамлын үрэнд тавих хяналтыг нийтийн аюулгүй байдлын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний улсын байцаагчхэрэгжүүлнэ.”

**2/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:**

“9.4.Үрийн хяналтын улсын байцаагч нь Хяналтын тухай хуулийн 20, 21, 22, 23 дугаар зүйлд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн гарчгийг “Таримал ургамлын үрийн чанарт тавих хяналт”гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын “торгох” гэсний дараа “хууль бусаар олсон орлогыг хураан авах, хуулийн этгээдийг татан буулгах” гэж нэмсүгэй.

**2 дугаарзүйл.** Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

### **1/13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дэх хэсэг:**

“13.1.Паркийн үйл ажиллагаанд дараахь зөрчил илэрсэн тохиолдолд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан холбогдох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналаа төрийн захиргааны төв байгууллагад гаргана;

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан саналыг үндэслэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон сэргээх эсэхийг шийдвэрлэнэ;”

### **2/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэлийг ногдуулна;”

**3 дугаар зүйл.** Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын “торгох” гэснийг “торгож” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 23.5 дахь хэсэг нэмсүгэй:

“23.5.Хүн болон мал, амьтны эм, биобэлдмэл, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний зах зээл дээрхи борлуулалт, худалдаа, тэдгээрийн экспорт, импортод тавих хяналтыг Хяналтын тухай хуулийн 7.3, 29-т заасан хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

**2 дугаарзүйл.**Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт:**

“6.2.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн стандарт (GMP)-ын хэрэгжилтэнд тавих хяналт;”

**2/29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт:**

“29.2.9.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй эм, биобэлдмэлийг худалдсан, 22.1, 23.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 400000-600000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 600000-1000000 төгрөгөөр торгох;”

**3 дугаарзүйл.**Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5 дахь заалтын“13 дугаар зүйл, 16.2-16.6-г” гэснийг “13.2, 16.5, 16.6-г.” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “нэгдсэн” гэснийг, 6.2.3 дахь заалтын “хяналт” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



## **ЭХИЙН СҮҮ ОРЛУУЛАГЧ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1.Эхийн сүүорлуулагч бүтээгдэхүүний тухай хууль тогтоомжийн биелэлтэд Хяналтын тухай хуулийн 7.3, 29-т заасан хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Амьтны тухайхуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “байцаагч” гэсний дараа “эсхүл байгаль хамгаалагч” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### **ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай” гэснийг “Хяналтын тухай” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>4.3</sup>-т” гэснийг “Хяналтын тухай хуулийн 9.3-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “төлбөр тогтоосон” гэсний дараа “болон үйл ажиллагааг түр зогсоосон” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсэг, 184 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 184.1, 184.2, 184.3 дахь хэсгийн “тогтоосон” гэсний дараа “болон үйл ажиллагааг түр зогсоосон” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатайдараах заалт нэмсүгэй:

“16.1.8.бусад хуулинд тухайн этгээдийг шинжээчээр ажиллахгүй байхаар тусгайлан заасан бол.”

**2 дугаар зүйл.** Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “16.1.7” гэсний дараа “16.1.8” гэж, 16.4 дэх хэсгийн “16.1.5” гэсний дараа “16.1.8” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ...-ныөдөр

Улаанбаатар  
хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хяналтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ